



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/105/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Н.Бунчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал.....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	14
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г ГАЛУУТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Д.АРИУНТУЯА
ТАНАА

Бодо.Од. 07 № 1/208
танай _____-ны № _____-т
Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020164


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Галуут сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Ариунцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.о.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 19-нөөс 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дах Төрийн аудитын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дах Төрийн аудитын газар 2020 оны 02 дүгээр сарын 18-ны өдрийн 41 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сумын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш, хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангах”-д оршино

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэнд-Амбулатори
- Хэвтэн эмчлүүлэх
- Оношилгоо
- Дэмжих үйлчилгээ

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Галуут сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Галуут сумын Эрүүл мэндийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Галуут сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 467472.8 мянган төгрөгөөс тооцон 9369.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22848,2 мянган төгрөгөөр буюу 2,2 хувиар

буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Авлага	1019.9	1019.9	0.0
Бараа материал	26942.3	28259.1	1316.8
Үндсэн хөрөнгө	1078528.2	1060927.6	-17600.6
Хуримтлагдсан элэгдэл	-100298.3	-106862.7	-6564.4
Нийт хөрөнгө	1006192.0	983343.9	-22848.2
Өр төлбөр	1329.9	664.2	-665.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1004862.1	982679.7	-22182.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1006192.0	983343.9	-22848.2

Авлага дансны үлдэгдэл өөрчлөлт гараагүй ба урд ажиллаж байсан нягтлан бодогчийн үед үүссэн 1019,8 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага тооцоо нийлсэн акт байхгүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1316,8 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 747,6 мянга, бусад хангамжийн материал 1259,6 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17600,6 мянган төгрөгөөр буурсан нь Галуут сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019.05.16-ны өдрийн 14 дугаар тогтоолоор тус байгууллагын үндсэн хөрөнгөнөөс 33481,7 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалжээ. Мөн төсвийн хөрөнгөөр 10960,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж хандив тусламжаар 4921,1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж орлого авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 928,1 мянган төгрөгөөр буурсан нь урд онд 1329,9 мянган төгрөгийн өртэй байсан ба ажиллагсадтай холбогдсон өглөг 928,1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна. Урд онд 328,4 мянган төгрөгийн эмийн өр одоо болтол барагдаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 983865,9 мянган төгрөг болж 20996,2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үеийн үр дүн 20996,2 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөтөлбөрт зориулан 445963,4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 445963,4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 370168,4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 40790,8 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 35004,2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд 445963,4 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 369829,9 мянга, орон нутгийн санхүүжилтээс 34895,7 мянга, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 37134,2 мянга нийт 441859,8 мянган төгрөг зарцуулж 346,5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 441859,8 мянган төгрөг буюу 99,1 хувьтай байгаа нь багаж техник хэрэгслийн зардал 3414,9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 271,0 мянга эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл 123,2 мянга, гэрэл цахилгааны зардал 100,9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд сорьц тээвэрлэлтийн зардал 150,2 мянган төгрөг орж зарцуулагдсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 32 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүллээ.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 32 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 26 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцлоо

Аудитаар нийт 12482,5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 187,8 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 12294,7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	12294.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	187.8	
3	Албан шаардлага өгсөн			
	Дүн	4	12482.5	

Аудитаар дараах 12482,5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 187,8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Тус байгууллагын нягтлан бодогч сантехникч Ю.Ерөөлт 2 сарын 1-нээс ажлаас чөлөөлөгдсөн байхад 2 сард 524,8 мянган төгрөгийн цалинг мэдээлж НДШ-д 102,8 мянган төгрөг, мөн сувилагч Л.Минжбадгарын 2019 оны 2,3 сарын нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалтын тайланг илгээхдээ кодыг буруу сонгож 640,0 мянган төгрөгийн цалинг илүү мэдээлж 85,0 мянган төгрөгийг тус тус төсвөөс илүү төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 6.4.8 төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 12294,7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Батлагдсан орон тоо, цалингийн сандаа багтаан ажиллаж байгаа байдал, хууль дүрмийн дагуу нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгож байгаа эсэх, бусад бараа үйлчилгээний зардлыг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд анхаарах нь зүйтэй гэж үзлээ

2.13. Шилэн дансны мэдээлэл

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 120 мэдээллийг хугацаанд нь, 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 4 мэдээллийг байршуулаагүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	4	3	4
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	30	6	
5	Тухай бүр	8	96	80	16	
6	Нийт	27	151	120	27	4

Бүтэн жилээр байршуулах 11 мэдээллээс хугацаанд 4 мэдээлэл, хугацаа хоцроож 3, байршуулаагүй 2 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Байршуулаагүй 2 мэдээлэл нь

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан

Улирал бүр мэдээлэх 4 мэдээллээс 1 мэдээлэл хугацаанд нь, 3 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан. Үүнд

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /1,3 дугаар улирал/

Сар бүр байршуулах 36 мэдээллээс 30 мэдээллийг хугацаанд нь 6 мэдээллийг хугацаа хоцроосон байна Үүнд

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /1-6 сар хүртэл/

Тухай бүр байршуулах 96 мэдээллээс 80 мэдээллийг хугацаанд нь 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Үүнд

- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт /1,2 сар/
- Цалингийн зардлаас бусад сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ /2,4,5 сар/
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл /2 сар/
- Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг /2,5,6,9 сарууд/
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл /2 сар/
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв,

өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр /1,2,5 сарууд/

- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт /2 сар/
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн /2 сар/

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, алба,н шаадлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Галуут сумын Эрүүл мэндийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн бусад бараа үйлчилгээний зардалд 27302,4 мянган төгрөг батлагдаж 27031,4 мянган төгрөг зарцуулагдсан байна. Үүний 70 хувь нь хүн амын эрүүл мэндийн боловсролын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, 30 хувь нь тухайн эмнэлгийн үйл ажиллагаанд зориулагдахаар төсөвт суугдсан байна. Зарцуулалтын хянаж үзэхэд сургалтыг зардлыг нийгмийн ажилтан Б.Эрдэнэцэцэгийн хувийн данс руу төсвөөс 4795,9 мянган төгрөг, Их номгон супермаркет руу цайны материалын үнэ 1714,5 мянган төгрөгийг шилжүүлж нягтлан бодогч, нярвын хяналтгүйгээр зарцуулсан зөрчил илэрлээ. Дээрх хөрөнгийг зарцуулахдаа сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг тухай бүр батлуулдаггүй сургалт хийгдсэн эсэхийг нотлох баримтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх, төсөв үр ашиггүй зарцуулагдах шамшигдах

1.3. Өгсөн зөвлөмж:

Бараа үйлчилгээний зардал гарах бүр Эрүүл мэндийн төвийн даргын тушаал шийдвэр гаргаж сургалтын хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан батлуулж нягтлан бодогчоор хянуулан сургалтын цайны материал болон сургалттай холбогдон гарч байгаа материалыг нярваар дамжуулан зарцуулж байх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт:

Тухайн байгууллага нь нягтлан бодох бүртгэл бодлогын баримт бичиггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Тус байгууллагын УСНББОУС-ын дагуу бүртгэл хөтлөхгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тухайн тайлант оны эхэнд 1019,8 мянган төгрөгийн авлагатай байсан ба одоо болтол барагдаагүй байна 2017 онд үүссэн авлага нь эзэн холбогдогч нь тодорхойгүй урд ажиллаж байсан нягтлан бодогч мэднэ гэсэн тайлбарыг өгөв. Харин оны эхэнд 1329,9 мянган төгрөгийн өглөгтэй байсан ба тайлант онд эцэст 664,2 мянган төгрөгийн өглөгтэй байна үүнд урд оноос үүссэн 328,3 мянган төгрөгийн эмийн өглөг байна.

3.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өглөг буруу илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд тусгагдсан 1019,8 мянган төгрөгийн авлагын эзэн холбогдогчийг тогтоож, төсвийн менежер хариуцан барагдуулан цаашид авлага өглөггүй ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

4. Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тухайн тайланд хугацаанд 445963,4 мянган төгрөгийн төсөв батлагдаж 441859,8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тусгай зориулалтын шилжүүлгээс 369829,9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 34895,7, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 37134,2 мянган төгрөгийн санхүүжилт авч 346,5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Тухайн байгууллага 2019 онд 26 орон тоо батлагдаж гүйцэтгэлээр 25 орон тоотой ажилласан байна. Эрхлэгч 1, их эмч 3, багийн бага эмч 5, эх барих бага эмч 1 орон тоо тус тус батлагдсан ба тухайн онд дээрх орон тоогоор ажиллаж байна. Гэтэл цалингийн санд суугдаагүй байхад эрхлэгч эмч нь их эмчийн 40 хувийн ажил хавсарсны нэмэгдэл 2364,7 мянган төгрөг, нийгмийн эрүүл мэндийн ажилтан бага эмчийн 20 хувийн цалингийн нэмэгдэлд 1687,9 мянган төгрөг тус тус авсан байна. Үүнийг Эрүүл мэндийн төвийн дарга Д.Ариунцэцэгээс тодруулахад 2018 оны 08 сарын 21-нээс чөлөө аваад эргээд 2019 оны 5 сарын 31-нд Галуут сумын засаг даргын Б/56 дугаар захирамжаар Эрүүл мэндийн төвийн даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон эрүүл мэндийн даргын хавсран ажилласны 40 хувийн нэмэгдлийг авч байгаа талаар хариу ирүүлэв.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 16.5.3 Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна

4.2. Эрсдэл

Батлагдсан төсөв зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх

4.3. Өгсөн зөвлөмж

Батлагдсан цалингийн сан орон тоондоо багтааж ажиллах Цаашид эрүүл мэндийн төвийн дарга томилогдсон тохиолдолд ажил хавсран ажилласны нэмэгдлийг авах байх, нийгмийн ажилтанд бага эмчийн 20 нэмэгдэл олгодог байдлыг зогсоох.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,962,172.00</u>	<u>29,278,985.56</u>
33	АВЛАГА	1,019,865.00	1,019,865.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,019,865.00	1,019,865.00
35	БАРАА МАТЕРИАЛ	26,942,307.00	28,259,120.56
351	Түүхий эд материал	196,472.00	224,284.00
35130	Эм боох материал	196,472.00	224,284.00
354	Хангамжийн материал	26,745,835.00	28,034,836.56
35410	Бичиг хэргийн материал	886,900.00	858,500.00
35420	Аж ахуйн материал	24,276,141.00	25,023,741.00
35460	Хүнсний материал	1,337,794.00	648,015.56
35470	Бусад хангамжийн материал	245,000.00	1,504,580.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>978,229,845.50</u>	<u>954,064,879.82</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	978,229,845.50	954,064,879.82
392	Биет хөрөнгө	934,771,845.50	910,606,879.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	839,668,838.01	839,668,838.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-21,291,697.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,032,143.00	66,032,143.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,637,053.55	-16,028,660.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	101,605,936.29	87,955,872.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-72,824,546.45	-59,296,699.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,251,054.00	13,300,512.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,431,831.61	-7,250,375.47
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,062,200.00	10,062,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,954,894.19	-2,545,252.70
393	Биет бус хөрөнгө	43,458,000.00	43,458,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	43,458,000.00	43,458,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,006,192,017.50</u>	<u>983,343,865.38</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,329,920.00</u>	<u>664,182.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,329,920.00	664,182.00
413	Өглөг	1,329,920.00	664,182.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,001,539.00	335,801.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	328,381.00	328,381.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,004,862,097.50</u>	<u>982,679,683.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,004,862,097.50	982,679,683.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	247,732,382.97	247,732,382.97
51101	Өмч: - төрийн	247,732,382.97	247,732,382.97
512	Хуримтлагдсан үр дүн	105,847,231.58	83,664,817.46
51210	Өмнөх үеийн үр дүн	105,847,231.58	105,847,231.58
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-22,182,414.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	651,282,482.95	651,282,482.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,006,192,017.50</u>	<u>983,343,865.38</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	424,116,333.12	447,476,565.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,523,615.12	5,120,075.00
120	Нийтлэг татварын бус орлого	40,523,615.12	5,120,075.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,523,615.12	5,120,075.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40,523,615.12	5,120,075.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	37,211,318.00	72,188,090.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	346,381,400.00	370,168,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,523,318.00	150,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,523,318.00	150,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	34,903,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	34,903,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,688,000.00	37,134,190.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	37,134,190.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	413,236,556.77	467,209,014.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	413,236,556.77	467,209,014.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	376,380,946.77	466,862,521.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,720,161.00	278,027,542.00
210101	Үндсэн цалин	209,866,485.00	274,619,179.00
210104	Урамшуулал	6,853,676.00	3,408,363.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,631,588.00	35,130,420.00
210201	Тэтгэврийн даатгал	25,631,588.00	35,130,420.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,409,826.00	31,895,713.13
210301	Гэрэл, цахилгаан	2,713,826.00	2,799,713.13
210302	Түлш, халаалт	28,696,000.00	28,696,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,441,678.00	21,397,285.00
210401	Бичиг хэрэг	3,858,520.00	705,400.00
210402	Тээвэр, шатахуун	12,268,100.00	17,570,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	737,858.00	866,885.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	479,300.00	2,254,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	693,600.00	00.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	404,300.00	00.00
2105	Нормативт зардал	28,055,693.00	40,112,485.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,137,531.00	31,028,707.00
210502	Хоол, хүнс	7,169,162.00	9,083,778.44
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	749,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,487,100.00	3,566,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	580,000.00	566,800.00
210604	Урсгал засвар	907,100.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,031,000.00	325,000.00
210702	Дотоод албан томилолт	1,031,000.00	325,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,000.00	400,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	124,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,479,900.77	56,007,276.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,394,618.00	17,601,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,499,400.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,585,882.77	38,406,076.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,855,610.00	346,492.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,707,118.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,688,000.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,019,118.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	148,492.00	7,986.87
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	148,492.00	7,986.87
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	338,506.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	338,506.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	10,879,776.35	-19,732,449.69
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	69,423,287.01	2,449,964.43
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	263,999.92	2,449,964.43
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	69,159,287.09	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-69,423,287.01	-2,449,964.43
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-58,543,510.66	-22,182,414.12

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	383,592,718.00	442,356,490.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	383,592,718.00	442,356,490.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	346,381,400.00	370,168,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,523,318.00	150,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,523,318.00	150,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	34,903,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	34,903,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,688,000.00	37,134,190.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,688,000.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	37,134,190.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	383,592,718.00	442,356,490.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	383,592,718.00	442,356,490.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,737,108.00	442,009,997.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,968,826.00	278,954,300.00
210101	Үндсэн цалин	164,246,741.00	205,785,200.00

210102	Нэмэгдэл	41,759,670.00	57,722,000.00
210104	Урамшуулал	8,962,415.00	15,447,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,662,700.00	34,869,400.00
210201	Тэтгэврийн даатгал	16,938,381.00	23,434,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,309,092.00	2,858,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,686,424.00	2,287,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	390,862.00	571,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,337,941.00	5,717,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,464,626.00	31,895,713.13
210301	Гэрэл, цахилгаан	2,547,686.00	2,799,713.13
210302	Түлш, халаалт	28,696,000.00	28,696,000.00
210303	Цэвэр, бохир ус	220,940.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	156,152,228.00	215,006,850.00
210401	Бичиг хэрэг	1,264,039.00	677,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,295,100.00	17,570,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	706,289.00	866,885.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,349,800.00	2,386,100.00
2105	Нормативт зардал	28,831,481.00	39,451,519.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,128,531.00	31,056,519.00
210502	Хоол, хүнс	7,199,950.00	8,395,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,503,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,014,000.00	7,431,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,230,500.00	3,031,800.00
210602	Тавилга	2,004,000.00	1,400,000.00
210604	Урсгал засвар	779,500.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	856,000.00	325,000.00
210702	Дотоод албан томилолт	856,000.00	325,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	550,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	150,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,324,247.00	27,031,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,824,847.00	27,031,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,499,400.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,855,610.00	346,492.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,707,118.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,019,118.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	148,492.00	7,986.87
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	148,492.00	7,986.87
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	338,506.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	338,506.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,732,382.97	651,282,482.95	105,847,231.58	1,004,862,097.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	247,732,382.97	651,282,482.95	105,847,231.58	1,004,862,097.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-22,182,414.12	-22,182,414.12
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,732,382.97	651,282,482.95	83,664,817.46	982,679,683.38

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	445,963,400.00	441,859,797.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	445,963,400.00	441,859,797.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	445,963,400.00	441,859,797.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,954,300.00	278,954,300.00
210101	Үндсэн цалин	205,785,200.00	205,785,200.00
210102	Нэмэгдэл	57,722,000.00	57,722,000.00
210104	Урамшуулал	15,447,100.00	15,447,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,869,400.00	34,869,400.00
210201	Тэтгэврийн даатгал	23,434,200.00	23,434,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,858,800.00	2,858,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,287,000.00	2,287,000.00

210204	Ажилгүйдлийн даатгал	571,800.00	571,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,717,600.00	5,717,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,004,200.00	31,895,713.13
210301	Гэрэл, цахилгаан	2,900,600.00	2,799,713.13
210302	Түлш, халаалт	28,703,600.00	28,696,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,686,700.00	21,500,685.00
210401	Бичиг хэрэг	677,000.00	677,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,570,700.00	17,570,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	916,000.00	866,885.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,523,000.00	2,386,100.00
2105	Нормативт зардал	39,574,700.00	39,451,519.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,179,700.00	31,056,519.00
210502	Хоол, хүнс	8,395,000.00	8,395,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,846,700.00	7,431,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,446,700.00	3,031,800.00
210602	Тавилга	1,400,000.00	1,400,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	325,000.00	325,000.00
210702	Дотоод албан томилолт	325,000.00	325,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000.00	400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27302400.00	27031380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,302,400.00	27,031,380.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	445,963,400.00	441,859,797.13
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	370,168,400.00	369,829,894.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	370,168,400.00	369,829,894.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,004,200.00	34,895,713.13
132001	Орон нутгийн төсвөөс	35,004,200.00	34,895,713.13
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,790,800.00	37,134,190.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	40,790,800.00	37,134,190.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөг/
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	150,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	150,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	150,200.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	150200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,200.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: *Н.Бунчинсүрэн* Н.БҮНЧИНСҮРЭН 2020.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР: *А.Цээням* А.ЦЭЭНЯМ 2020.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *Б.Мөнхбат* Б.МӨНХБАТ 2020.02.25

